



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Нүүдэлчдийн өвөл-2011 “Мөсөн шагайн наадам” зохион байгуулах тухай

Монгол Улсын “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/22 дугаар тогтоол, 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015 хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Улаанбаатар хотын аялал жуулчлал -2015” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2011 оныг Хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах Улаанбаатар хот, хотын орчимд жуулчдын сонирхолыг татах, үндэсний ёс заншил, тоглоом наадгайг гадаад, дотоодын жуулчдад сурталчилан таниулах зорилгоор Нүүдэлчдийн өвөл 2011 “Мөсөн шагайн наадам” арга хэмжээг 2011 оны 02 сарын 06–ны өдөр Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт зохион байгуулахыг эвент хариуцсан мэргэжилтэн /Г.Нямцогт/ -д, үүрэг болгосугай.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжлийг дэмжиж жилийн хүрээнд Нүүдэлчдийн өвөл 2011, “Мөсөн шагайн наадам” арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Нүүдэлчдийн өвөл 2011, “Мөсөн шагайн наадам” арга хэмжээг зохион байгуулах зардал 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг тус газрын 2011 оны батлагдсан төсвөөс гаргахыг ахлах ня-бо /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээлэлээр сурталчлах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/ -д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

My Doc/tushaal/

1111501000-3